

**“Авилгалтай тэмцэж шударга ёсыг тогтоон  
бэхжүүлэх нь: Асуудал ба Шийдэл” оюутны эрдэм  
шинжилгэний хуралд**

**ШУТИС-ын ЭХИС Сэргээгдэх Эрчим Хүч 2-р курс  
Алтан-Очирын Оюун-Эрдэнэ**

## Авлига ба ирээдүй

### Оршил

“Бурхад хүнд атаархадаг” гэдэг үг хүн төрөлхтөнд шинэ цаг үеийг авчирсан. Энэ үгийг би хуульч, УИХ-ын гишүүн Х.Тэмүүжингийн “Үгс” номноос анх хараад Бурхад хүнд атаархах ямар шалтгаан байдаг байна аа? гэж их сониучирхаж байж билээ. Тэгээд цааш үргэлжлүүлэн уншвал энэ нь өөрөө эрх чөлөөний философи болох Либертари үзэлийн тухай болохыг ойлгосон. Үүний мөн чанар нь хүн эрх чөлөөтэй байдаг. /сонгох, алдах, онох гээд л/ Харин бурхад бол төгс төгөлдөр учир тэдэнд алдах эрх гэж үгүй ба тэр ч байтугай “ Алдах гэсэн Сонголт” хийнэ гэдэг тэдний хувьд “шилний цаанаас чихэр долоохтой” адил нэг тиймэрхүү мөрөөдөл төдий л зүйл. Тиймээс л хүмүүсийн энэ эрх чөлөөнд Бурхад атаархдаг гэсэн санаа юм билээ.

Бурхадын эдэлж, мэдэрч чадахгүй тэрхүү эрх чөлөөг, түүнийх нь мэдрэмжийг хүн төрөлхтөн тэр дундаа бүхэл бүтэн нэг зууны тэн хагасыг дарангуйлалын дэглэм дор өнгөрөөсөн Монголчууд эдэлж мэдэрнэ гэдэг өөрөө онцлог зүйл юм. 1990 онд Монгол залуус янз янзын арга замаар тэрч байтугай амь насаараа хүртэл дэнчин тавьж төр засгаас төрийн тогтолцоог өөрчлөхийг хүсэн шаардлагуудыг тавьсан нь ертөнцийн сонорт хүрсэн. Удалгүй Ройтерс, Ассошейтедпресс, Франспресс зэрэг дэлхийн томоохон агентууд Монголыг ажиглан анхаарч эхлэн “Хоёр том гүрний дундах энэ жижигхэн орон Ардчилалын бамбарыг Ази тивд анх түрүүнд асааалаа. Учирч болох бэрхшээл саадыг хэрхэн давж, тэсч гарах бол!” гэх мэтээр дэлхийд Монгол цуурайтах болсон байна.

Монголчууд бид уужуу тайван ухаанаар дусал цусны ч толбогүйгээр төрийн тогтолцоог Ардчилсан замаар өөрчилсөн нь Монголчууд ямар их тэсвэр тэвчээр, улс төрийн өндөр соёлтойгоо дэлхий дахинд харуулсан үе байсан. 1990 оны тэмцэлд хүмүүс улс орон, ард түмний эрх ашгийн төлөө ухамсартайгаар нэгдэн нягтарч чадсан нь Зориг агсны хэлдгээр “Эцсийн эцэст улс үндэстний эрх ашиг гэдэг бол ямар ч улс төрийн хүчний эрх ашиг, ямар ч сонирхлоос дээгүүр зүйл” гэдэгийг баталж чадсан үйл явдал байсан юм.

Тэгвэл тэрхүү 1990 онд бүтээсэн ардчилал маань өнөөдөр хаана явж байна? Их Британийн “The Economist” сэтгүүл “Дэлхийн улс орнуудын ардчиллын индекс”-ийг хоёр жил тутамд зарладаг бөгөөд Индекс-ийн гол үзүүлэлт нь

- сонгуулийн үйл явц,
- Засгийн газрын үйл ажиллагаа,
- улс төрийн оролцоо,
- улс төрийн соёл,
- иргэний эрх чөлөө гэсэн 5 зүйл дээр суурилдаг байна.

Ардчиллын индекс нь улс орнуудын ардчиллын төвшнийг илтгэдэг ба тухайн улсын нийгмийн санаа бодолд тулгуурлан гаргасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтэд үндэслэдэг юм байна. Харин Монгол Улс 2006 онд уг индексийн 56, 2008 онд 58 дугаарт жагсаж байсан ч 2010 онд манай ардчиллын гол үзүүлэлтүүд буурсны улмаас зургаан байр ухарч 64 дүгээрт оржээ. Бид ухарч одоо ч ухарсаар байна. Үүний гол шалтгаан нь ардчилалын гол үзүүлэлт болсон дээрх 5 зүйл авилгал хэзээ хахуультай хутгалдаж эхэлсэнтэй холбогдон тайлбарлагдан. Үүний хамгийн энгийн жишээнд сонгуулийн олон худал шоунууд болоод хүмүүсийн саналыг мөнгөөр худалдан авагсадын бохир үйл ажиллагаа багтана.

- **Авилга** түүний шалтгаан ,цар хүрээ,**учруулж буй аюул занал** хичнээн аюултай, аймшигтай төсөөллөхийн аргагүй
- Авилгад хэт автагдаж, бид хяналтаа алдвал
  - төрийн үйлчилгээний** үр ашиг, үр нөлөө илт буурч
  - **Шийдвэр гаргах үйл явц** далд хувилдаанд хийгдэх болж, эрх тэгш байдал алдагдаж
  - **Төсөв болон хууль** өөрөө нийгмийн ядуу, эмзэг бүлгийн гишүүдийн хүсэл шаардлагад нийцэхээ больно. Өөрөөр бол бидний өнөө бүтээсэн ардчилал маань конец фильма болно гэсэн санаа.

**Авилгын тухай хуучны тоо баримтаас:** 1999 оны шалгалтын нэгэн мэдээнээс та бүхэн улсын сангийн хөрөнгө хэрхэн хоосордогийг хараад ухаа алдах байхдаа. АНУ-ын жижиг ,дунд үйлдвэрийг дэмжих сангийн

хөрөнгөнөөс аж ахуй нэгж,хувь хүнд олгосон-**1 тэрбум 592 сая ₮** төгрөгийн 88,4% нь- хугацаа хэтэрч, 40,6% нь- эргэж төлөх найдваргүй болжээ.Энэ нь ойролцоогоор 600 сая төгрөг гэсэн үг.

Сургалтын төрийн сан гэж байдаг.Энэ сан гадаад дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаа болон хүмүүсийн сургалтын зээл болох **-8,5тэрбум ₮** төгрөгийг сангийн дансандаа огт тусгаагүй, тодруулбал нуужээ. Энэ бол төрийн хөрөнгө, та бидний мөнгө. Төсөөлдөө 8 миллиард 500 сая...


СТСан 1998 онд **3 тэрбум 12 сая ₮** зарцуулсан байна.Энэ нь мөн л гадны болон дотоодын их, дээд сургуульд суралцах 9096 оюутанд-**1 тэрбум 757,2сая ₮** , гадаадын магистрантур,аспирантурт суралцагсадад тодруулбал 161 хүнд - **2,1 сая \$** америк доллар заржээ.

Уг нь сургалтын төлбөрийг тухайн сургуулийн дансанд хийх ёстой байтал, СТСан 1998-1999 онд 61 оюутны **-798 мян \$** хувийн дансанд хийсэн байна.

Мөн түүнчлэн гадаадад суралцагсадын төлбөрийг өөрсдөө дур мэдэн нэмж,шилжүүлсэн СТСангийн ажилтнуудч гарч байжээ.1998 онд АНУ-д суралцаж байсан С.Боргилын сур/төлбөр **22985 \$** байсныг **27985 \$** болгож /**5000 \$** илүү бодсон/ 1999 онд АНУ-д суралцаж байсан Ц.Гэрэлтуяагийн сур/төлбөр **49583 \$** байсныг **52658 \$** болгон /**3065 \$** тус тус илүү боджээ/.Энэ мэтчилэн олон төрийн байгууллагуудын хөрөнгө мөнгө,төсөв нь сураггүй байхгүй болсон олон баримт байна./**Холоос тээсэн бодол-Г.Золжаргал 163-165р тал/**

## Өнгөрсөн 3 жилд авилгын түвшин өөрчлөгдсөн үү?

- Авилгын талаарх олон нийтийн төсөөлөл



## Аль нь авилгалд хамгийн их автсан бэ?



- Төрийн байгууллагуудыг авилгын түвшингээр жигсвэсэн асуумж судалгааны үр дүнд Газрын алба тэргүүлж Уул уурхайн салбар удаалжээ


График 3. Дунд байгууллагын авилгалд хамгийн их автсан салбарыг хайна?

Салбар	Байгууллага
1	Газрын алба
2	Уул уурхайн салбар
3	Шүүх, цагдаагийн байгууллага
4	Газар
5	Энх туслах ажил
6	Туслах ажиллагаа байгууллага
7	Хөдөлгөөн байгууллага
8	Газар
9	Бусад, өөрөөр өгөгдөлийг авч үзэхгүй (Хүндэтгэл, гэрээний байгууллага, хөдөлгөөн, өргөмжлөл, өргөмжлөл, өргөмжлөл)
10	Туслах ажиллагаа байгууллага
11	Туслах ажил
12	Бусад ажиллагаа байгууллага
13	Өргөмжлөл

**Ирэх 3 жилд авилгын түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?**




- Авилгын түвшин буурна гэдэгт хүмүүсийн итгэл СУЛ байгаа нь ихээхэн буурна гэсэн хариултад 2,8% тай хариулнаао харагдана.**



**Та эсвэл таны гэр бүлийн гишүүн хахууль өгсөн үү?**



- Хахууль өгсөн өрхийн эзлэх хувь болон хахуулийн хэмжээ**
- 2006-2010 онд 9%-иар буурсан байна.**
- Тэр онд 3% -иар буурчээ**




## Та хичнээн төгрөгийг хахуульд өгсөн бэ?



### ■ **Хахуулийн**

дундаж  
хэмжээ  
мянган төг  
/1000₮/



## Нийт өрхийн хахуульд өгсөн мөнгөн дүн

- **Хахууль өгсөн өрхийн хувь хэмжээ 2010 онд 2008 оноос 9%-иар буурсан хэдий ч нийт 2010 онд хахуулийн дүнг нь 10тэрбумаар өссөн үзүүлэлтэй байна.**

Түгшлэл 22. Нийт өрхийн хэргийн өртөгний дүн (төг)

	2006	2007	2008	2009	2010
<b>Нийт өртөг</b>					
Хувьцаа	10	15	12	17	18
Хувьцаагүй	10	15	12	17	18
Хувьцаа бүхий өртөг	20	30	24	34	36
Хувьцаагүй өртөг	10	15	12	17	18
Хувьцаа бүхий өртөгний дүнгийн хувь	20	30	24	34	36

/Авилга ба ирээдүй/ Хүүхдүүд томчуулын тусгал:

Хүүхэд өсөж байгаа

орчин, өсгөж байгаа ээж аавынхаа толь болдог. Томчуудыг тэд үргэлж

дуурайна.Бас нөлөөнд нь амархан автана.Жаахан дүү нарыг маань ямар ирээдүй хүлээж байна вэ? Хүүхдүүд өөрсөдөө үүнд хариулна.

1-р дэхь бичлэг: **Манай ангийн хүүхдийн аав нь манай багшид мөнгө өгсөн.**

- Чиний нэрийг хэн гэдэг вэ? -Эрдэнэ-Очир.
  - Чи хэдэн настай вэ? -арав.
  - Чи хэддүгээр ангид сурдаг вэ? -тавдугаар анги.
1. Чи авилгал хээль хахууль гэдэг үгийг сонсож байсан уу?,мэдэх үү?  
-Сонсож байсан
- Тийм бол энэ үгийг яаж мэддэг болсон бэ?  
-Амьдралаасаа тэгээд том болоод,зурагтмурагт,ээж аав маваасаа,багш магшаасаа мэддэг болсон.
2. Энэ ямар утгатай үг вэ?  
-Хүнд мөнгө өгөөд юм хийлгэх.
- Чамд тохиолдсон жишээ байна уу?  
-Манай ангийн муу сурдаг хүүхдийн аав нь багшид их хэмжээний мөнгө өгөөднц гаргуулсан.Үүнийг би жорлонгийн өрөөнөөс ангируугаа орж ирэхдээ харссан.
3. Ээж аав чинь чиний сайн сайхны төлөө хэн нэг хүнд зайлшгүй бэлэг өгөх хэрэгтэй болбол чи буруутгах уу?,зөвтгөх үү?  
-ЗөвтгөнөьМиний сайн сайхны төлөө учраас.

2-р дахь бичлэг:**Би удмаа бузарлахгүй**

Мөнх-Эрдэнэ,13 настай, 7-р ангийн сурагч

Асуулт 1: –мэднэ, хээл хахууль гэдэг нь авилга гэдэг үгийг монголоор хэлж байна.

Асуулт 2:-Хүнд мөнгө өгч хүнээр юм хийлгэх.

Асуулт 3:-Буруутгана, Би удмаа тэгж бузарлахгүй.

3-р дахь бичлэг:**Хүн өөрийнхөө хүчээр амьдрах ёстой.**

Тэмүүжин,11 настай,5-р ангийн сурагч

Асуулт 1:Сонсож байсан,/цэцэрлэгтээ/ мэднэ

Асуулт 2:Хүүхдүүдийг муу сурвал эцэг эхчүүд нь мөнгө,авилгал өгч онц гаргуулах.

- Авилгал өгөх нь буруу юу? Зөв үү?



-Буруу,хүн өөрийнхөө хүчээр амьдрах ёстой.

Асуулт 3:Аав ээж ажил хийж намайг сургуульд оруулна.Бүүр болохгүй бол би өөрөө ажил хийж чадна.

Хүүхдүүд ингэж хариулжээ. Тэд биднийг л дуурайна.

***Шийдэл:***

- Судалгаагаар,тоо баримтаар,зарим ярилцлагаар бид авилгалд идэгдсэн гэдэг нь их тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл бидэнд асуудал байна. Тэгвэл шийдэл нь юу вэ? Бид юу хийж чадах вэ?
- Бид ЕБС-ийн сурагчдад авилагын талаар цэгцтэй, тэдний нас сэтгэхүйд таарсан мэдлэг,мэдээлэл өгөх хэрэгтэй
- Нийгмийн оролцоог дээшлүүлэх, идэвхижүүлэх

-Олон нийтийн оролцоотойгоор шийдвэр гаргах нь үйл ажиллагааны ил тод байдалд нөлөөлнө.

-Олон нийтэд мэдээллийг түгээх,мэдээлэл олох боломж бий болгох.

-Авилгыг үл тэвчих үзэл бодлыг бий болгохын тулд олон нийтийн боловсролын хөтөлбөрүүдийг ЕБС болон их,дээд сургуулийн оюутан сурагчдын дунд зохион байгуулах.

-Авилгалтай холбоотойгоор мэдээлэл хайх,сурвалжлага бэлтгэх,бичиж нийтлэхийг сайн дэмжих нь хамгйн сайн шийдлүүд болно.